



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 244

Улаанбаатар хот

**「Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл」
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Тогтвортой амьжиргаа-3” төслийн нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 113,800,000.00 (нэг зуун арван гурван сая найман зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 6033 УНХ улсын дугаар, JN1TANY62Z0030049 арлын дугаартай, Ниссан патрол-У61 маркийн тээврийн хэрэгслийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч Хэнтий аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Г.Лхагвахатан, Хэнтий аймгийн Бор Өндөр сумын Засаг дарга Г.Адъяабилэгт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээд (Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар)-т эзэмшүүлэх, засаж сэлбэн ашиглах, үнийг шинэчлэн тогтоож данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Автомашиныг автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл, тавар төлөгчийн бүртгэлээс хасч шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ
123007544
37-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



Тогтвортой амьжиргаа-3 төслийн үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй Хэнтий аймгийн өмчид балансаас
балансад шилжүүлэх автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ниссан патрол-У61, 6033 УНХ, арал№ JN1TANY62Z0030049	2016/ 2016	113,800,000.00	00
	Нийт дүн		113,800,000.00 (нэг зуун арван гурван сая найман зуун мянган)	00